

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Малчин сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2022/139/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Улаангом хот

2022 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,

Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан

Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn

Аудитор: Б.Одгэрэл

Утас: 70453721, Цахим хаяг: Ayushr@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1. Аудитын санал дүгнэлт .....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	3
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал .....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт .....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	15

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС

Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**УВС АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,  
Ө.Бадрахын гудамж  
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,  
E-mail: uvs@audit.gov.mn

2022.02.25 № УВА-139/НА-СТА-ТШЗ

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

МАЛЧИН СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Х.АЛИМАА ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Малчин сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Малчин сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

0200200224

2.1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>39,628,650.75</b>	<b>43,215,408.67</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	00.00	380,758.96
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	00.00	380,758.96
3351	Байгууллагаас авах авлага	00.00	380,758.96
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	39,628,650.00	42,834,649.71
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	96,800.00	96,800.00
35130	Эм боох материал	96,800.00	96,800.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	39,531,850.00	42,737,849.71
35420	Аж ахуйн материал	38,945,550.00	41,891,049.71
35440	Түлш, шатах тослох материал	380,000.00	380,000.00
35460	Хүнсний материал	206,300.00	466,800.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,537,688,078.83</b>	<b>1,451,342,497.15</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,537,688,078.83	1,451,342,497.15
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,490,390,078.83	1,404,044,497.15
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,847,647,592.00	1,847,647,592.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-524,270,028.53	-601,175,609.57
39203	Авто-тээврийн хэрэгсэл	42,027,800.00	42,027,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-3,502,316.65	-11,907,876.61
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	161,848,613.00	177,496,613.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-108,995,726.04	-126,634,606.06
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	141,954,556.00	159,046,556.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-81,308,727.53	-98,083,667.71
39214	Бусад үндсэн хөрөнгө	21,158,200.00	21,158,200.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-18,480,453.92	-19,480,103.84
39217	Ном	12,310,570.50	13,949,599.94
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>47,298,000.00</b>	<b>47,298,000.00</b>
39301	Программ хангамж	740,000.00	740,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-740,000.00	-740,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	47,298,000.00	47,298,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,577,316,728.83</b>	<b>1,494,557,905.82</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,577,316,728.83</b>	<b>1,494,557,905.82</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,577,831,069.69	983,824,307.52
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	574,938,161.15	574,938,161.15
51101	Өмч: - төрийн	574,938,161.15	574,938,161.15
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	499,595,763.33	416,836,940.32
51210	Өмнөх үеийн үр дүн	499,595,763.33	499,595,763.33
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-82,758,823.01
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	502,782,804.35	502,782,804.35
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,577,316,728.83</b>	<b>1,494,557,905.82</b>

2.2. АУДИТ ХИЙСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,085,654,502.00</b>	<b>932,613,580.15</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>69,036,102.00</b>	<b>5,963,929.15</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	69,036,102.00	5,963,929.15
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	69,036,102.00	5,963,929.15
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	69,036,102.00	5,963,929.15
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>132,267,200.00</b>	<b>126,769,351.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	884,351,200.00	799,880,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>22,000,000.00</b>	<b>4,872,251.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,000,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	4,872,251.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>110,267,200.00</b>	<b>121,897,100.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	110,267,200.00	121,897,100.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,095,637,668.49</b>	<b>1,015,372,403.16</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,095,637,668.49</b>	<b>1,015,372,403.16</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,041,196,396.49</b>	<b>980,763,207.90</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>656,693,832.00</b>	<b>613,481,641.84</b>
210101	Үндсэн цалин	428,749,358.00	404,142,774.29
210102	Нэмэгдэл	161,584,888.00	161,070,733.58
210104	Урамшуулал	56,375,388.00	38,190,257.00
210105	Гэрээт ажлын хөлс	9,984,198.00	10,077,876.97
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>82,124,860.00</b>	<b>79,825,736.12</b>
210201	Тэтгэврийн даатгал	55,832,850.00	55,854,318.79
210202	Тэтгэмжийн даатгал	6,591,100.00	6,126,482.45
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,253,516.00	4,901,185.59
210204	Ажилгүйдлийн даатгал	1,313,452.00	1,150,168.57
210205	Эрүүл мэндийн даатгал	13,133,942.00	11,793,580.72
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>106,979,903.00</b>	<b>119,223,357.82</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,523,143.00	4,645,530.00
210302	Түлш, халаалт	104,289,360.00	114,444,827.82
210303	Цэвэр, бохир ус	167,400.00	133,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>23,433,734.00</b>	<b>8,753,111.00</b>
210401	Бичиг хэрэг	817,500.00	605,251.00
210402	Тээвэр, шатахуун	8,094,234.00	2,935,260.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	843,500.00	843,500.00
210404	Ном, хэвлэл	145,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,811,000.00	3,265,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,722,500.00	1,103,600.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>23,754,410.00</b>	<b>27,077,250.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	135,700.00	460,200.00
210502	Хоол, хүнс	23,075,860.00	26,617,050.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	542,850.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,500,000.00</b>	<b>2,500,000.00</b>
210604	Урсгал засвар	2,500,000.00	2,500,000.00

Малчин сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,550,000.00	400,000.00
210702	Дотоод албан томилолт	1,550,000.00	400,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	23,158,000.00	1,211,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,500,000.00	500,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	160,000.00	403,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	498,000.00	308,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	121,001,657.49	128,290,911.12
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,474,000.00	7,566,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	117,527,657.49	120,724,611.12
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	54,441,272.00	34,609,195.26
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	11,915,500.00	14,916,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,840,500.00	14,081,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,075,000.00	835,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	42,525,772.00	19,692,795.26
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	42,525,772.00	19,692,795.26
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-9,983,166.49</b>	<b>-82,758,823.01</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-9,983,166.49</b>	<b>-82,758,823.01</b>

2.3. АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,016,618,400.00</b>	<b>926,649,651.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,016,618,400.00</b>	<b>926,649,651.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	884,351,200.00	799,880,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	22,000,000.00	4,872,251.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,000,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	4,872,251.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	110,267,200.00	121,897,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	110,267,200.00	121,897,100.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,016,618,400.00</b>	<b>926,649,651.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,016,618,400.00</b>	<b>926,649,651.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>962,177,128.00</b>	<b>892,040,455.74</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	656,693,832.00	613,481,641.84
210101	Үндсэн цалин	428,749,358.00	404,142,774.29
210102	Нэмэгдэл	161,584,888.00	161,070,733.58
210104	Урамшуулал	56,375,388.00	38,190,257.00
210105	Гэрээт ажлын хөлс	9,984,198.00	10,077,876.97
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	82,124,860.00	80,206,495.08
210201	Тэтгэврийн даатгал	55,832,850.00	56,235,077.75
210202	Тэтгэмжийн даатгал	6,591,100.00	6,126,482.45
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,253,516.00	4,901,185.59
210204	Ажилгүйдлийн даатгал	1,313,452.00	1,150,168.57
210205	Эрүүл мэндийн даатгал	13,133,942.00	11,793,580.72
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	107,359,903.00	119,223,357.82
210301	Гэрэл, цахилгаан	2,523,143.00	4,645,530.00
210302	Түлш, халаалт	104,669,360.00	114,444,827.82
210303	Цэвэр, бохир ус	167,400.00	133,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	24,053,633.00	9,418,711.00
210401	Бичиг хэрэг	817,500.00	1,035,251.00
210402	Тээвэр, шатахуун	8,094,234.00	2,935,260.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	843,500.00	843,500.00
210404	Ном, хэвлэл	379,899.00	381,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,811,000.00	3,119,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,107,500.00	1,103,600.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	20,467,800.00	28,862,750.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	232,500.00	432,500.00
210502	Хоол, хүнс	18,448,450.00	26,882,050.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,786,850.00	1,548,200.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	42,797,100.00	31,500,000.00

Малчин сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210601	Багаж, техник, хэрэгсэл	22,297,700.00	29,000,000.00
210602	Тавилга	17,999,400.00	00.00
210604	Урсгал засвар	2,500,000.00	2,500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,550,000.00</b>	<b>400,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,550,000.00	400,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>23,158,000.00</b>	<b>1,211,200.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,500,000.00	500,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	160,000.00	403,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	498,00.00	308,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>3,972,000.00</b>	<b>7,736,300.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,972,000.00	7,736,300.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>54,441,272.00</b>	<b>34,609,195.26</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>11,915,500.00</b>	<b>14,916,400.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,840,500.00	13,856,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,075,000.00	1,060,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>42,525,772.00</b>	<b>19,692,795.26</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	42,525,772.00	19,692,795.26
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>

## 2.4. АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>574,938,161.15</b>	<b>504,128,648.06</b>	<b>508,233,086.11</b>	<b>1,587,299,895.32</b>
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	335,916.67	335,916.67
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>574,938,161.15</b>	<b>362,239,181.02</b>	<b>508,569,002.78</b>	1,587,558,263.95
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-1,517,601.61	-1,517,601.61
C08	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>574,938,161.15</b>	<b>502,860,352.39</b>	<b>499,518,215.29</b>	<b>1,577,316,728.83</b>
D01	<b>2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>574,938,161.15</b>	<b>502,860,352.39</b>	<b>499,518,215.29</b>	<b>1,577,316,728.83</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>574,938,161.15</b>	<b>502,860,352.39</b>	<b>499,518,215.29</b>	<b>1,577,316,728.83</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-82,758,823.01	-82,758,823.01
D09	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>574,938,161.15</b>	<b>502,860,352.39</b>	<b>-416,836,940.32</b>	<b>1,494,557,905.82</b>

## 2.5. АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	921,777,400.00	902,084,604.74	19,692,795.26	97.86
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	921,777,400.00	902,084,604.74	19,692,795.26	97.86
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	905,756,800.00	887,168,204.74	18,588,595.26	97.95
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	616,941,700.00	613,481,641.84	3,460,058.16	99.44
210101	Үндсэн цалин	406,317,300.00	404,142,774.29	2,174,525.71	99.46
210102	Нэмэгдэл	162,348,700.00	161,070,733.58	1,277,966.42	99.21
210104	Урамшуулал	38,195,700.00	38,190,257.00	5,443.00	99.99
210105	Гэрээт ажлын хөлс	10,080,000.00	10,077,876.97	2,123.03	99.98
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	83,287,100.00	80,206,495.08	3,080,604.92	96.30
210201	Тэтгэврийн даатгал	58,609,500.00	56,235,077.75	2,374,422.25	95.95
210202	Тэтгэмжийн даатгал	6,169,400.00	6,126,482.45	42,917.55	99.30
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,935,500.00	4,901,185.59	34,314.41	99.30
210204	Ажилгүйдлийн даатгал	1,233,900.00	1,150,168.57	83,731.43	93.21
210205	Эрүүл мэндийн даатгал	12,338,800.00	11,793,580.72	545,219.28	95.58
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	119,397,100.00	119,223,357.82	173,742.18	99.85
210301	Гэрэл, цахилгаан	4,650,000.00	4,645,530.00	4,470.00	99.90
210302	Түлш, халаалт	114,447,100.00	114,444,827.82	2,272.18	100.00
210303	Цэвэр, бохир ус	300,000.00	133,000.00	167,000.00	44.33
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	8,980,200.00	8,846,460.00	133,740.00	98.51
210401	Бичиг хэрэг	866,000.00	863,000.00	3,000.00	99.65
210402	Тээвэр, шатахуун	2,937,000.00	2,935,260.00	1,740.00	99.94
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	843,500.00	843,500.00	-	100.00
210404	Ном, хэвлэл	381,400.00	381,400.00	-	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,720,000.00	2,719,700.00	300.00	99.99
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,232,300.00	1,103,600.00	128,700.00	89.56
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	40,019,500.00	28,862,750.00	11,156,750.00	72.12
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	432,500.00	432,500.00	-	100.00
210502	Хоол, хүнс	37,798,900.00	26,882,050.00	10,916,850.00	71.12
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,788,100.00	1,548,200.00	239,900.00	86.58
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	31,500,000.00	31,500,000.00	-	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	29,000,000.00	29,000,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	2,500,000.00	2,500,000.00	-	100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	688,200.00	400,000.00	288,200.00	58.12
210702	Дотоод албан томилолт	688,200.00	400,000.00	288,200.00	58.12

Малчин сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,503,200.00	1,211,200.00	292,000.00	80.57
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	500,000.00	500,000.00	-	100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	403,200.00	403,200.00	-	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	600,000.00	308,000.00	292,000.00	51.33
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	3,439,800.00	3,436,300.00	3,500.00	99.90
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,439,800.00	3,436,300.00	3,500.00	99.90
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	16,020,600.00	14,916,400.00	1,104,200.00	93.11
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	16,020,600.00	14,916,400.00	1,104,200.00	93.11
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	14,945,600.00	13,856,400.00	1,089,200.00	92.71
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,075,000.00	1,060,000.00	15,000.00	98.60
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	921,777,400.00	902,084,604.74	19,692,795.26	97.86
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	799,880,300.00	780,187,504.74	19,692,795.26	97.54
131001	Улсын төсвөөс санхүүжих	799,880,300.00	780,187,504.74	19,692,795.26	97.54
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	121,897,100.00	121,897,100.00	-	100.00
132001	Орон нутгийн төсвөөс	121,897,100.00	121,897,100.00	-	100.00

2.6. АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>4,872,251.00</b>	<b>-4,872,251.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>4,872,251.00</b>	<b>-4,872,251.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>4,872,251.00</b>	<b>-4,872,251.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		572,251.00	-572,251.00
210401	Бичиг хэрэг		172,251.00	-172,251.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		400,000.00	-400,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>		4,300,000.00	-4,300,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		4,300,000.00	-4,300,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>4,872,251.00</b>	<b>-4,872,251.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		4,872,251.00	-4,872,251.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		4,872,251.00	-4,872,251.00

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны Малчин сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Одгэрэл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Малчин сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Малчин сумын Ерөнхий боловсролын сургууль нь хүүхдийн хөгжлийг дэмжих, суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгах, амжилттай суралцахад бүх талын оролцоог хангаж, хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж, иргэнийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхтай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэх, багш мэргэжлээрээ тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэх үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг Төсвийн тухай хуульд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагатай гэж үзэж шалгахад дотоод аудитын чиг үүрэг бүхий байгууллагуудаас тайлант онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Малчин сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 4,382.6 мянган төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,015,372.4 мянган төгрөгөөс 0.5 хувиар буюу 5,076.9 мянган төгрөгийн 80 хувиар буюу 4,061.5 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлан гарах цаглаварт хугацаа болоогүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар дахин шинэчлэн тогтоосон.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Малчин сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 82,758.8 мянган төгрөгөөр буюу 5.2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	0.0	380.8	380.8
Бараа материал	39,628.7	42,834.6	3,205.9
Үндсэн хөрөнгө	1,537,688.1	1,451,342.5	-86,345.6
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,577,316.7</b>	<b>1,494,557.9</b>	<b>-82,758.8</b>
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,577,316.7	1,494,557.9	-82,758.8
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,577,316.7</b>	<b>1,494,557.9</b>	<b>-82,758.8</b>

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлгүй байна.

Авлага дансны үлдэгдэл 380.8 мянган төгрөг болж 380.8 мянган төгрөгөөр өссөн нь нийгмийн даатгалын шимтгэлийн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 42,834.6 мянган төгрөг болж 3,205.9 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал зарцуулагдаагүй үлдсэнээс шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,451,342.5 мянган төгрөг болж 86,345.6 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 34,379.0 мянган төгрөг, хандив болон үнэ төлбөргүй

шилжүүлэн авсан 4,097.6 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, тайлант онд 120,724.6 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсонтой холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,494,557.9 мянган төгрөг болж 82,758.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн хасагдсанаас шалтгаалжээ.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 153,040.9 мянган төгрөгөөр буюу 14.1 хувиар буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 80,265.3 мянган төгрөгөөр буюу 7.3 хувиар буурсан байна. Үүнд хангамж бараа материалын зардал, томилолтын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлууд нөлөөлсөн байна.

Тайлант онд өр төлбөр үүсээгүй байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Малчин сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,210,571.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,210,571.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 288,793.9 мянган төгрөгийн цалин, эд хогшил, урсгал засварын зардлуудыг бууруулж, 921,777.4 мянган төгрөгөөр баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 921,777.4 мянган төгрөгийн төсөв баталснаас улсын төсвөөс 799,880.3 мянга, орон нутгийн төсвөөс 121,897.1 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын болон орон нутгийн төсвөөс 921,777.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 902,084.6 мянган төгрөгийг зарцуулж 19,692.8 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 902,084.6 мянган төгрөг буюу 97.9 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Малчин сумын Ерөнхий боловсролын сургуулийн нэмэлт санхүүжилтийн дансаар дээд шатны төсвийн захирагчаас 4,872.3 мянган төгрөгийн орлого орсныг зарцуулалтын эрх нээлгэн зориулалтын дагуу зарцуулсан байна.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Малчин сумын Ерөнхий боловсролын сургуулийн хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байсан тул Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахгаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 125, хугацаа хоцроож мэдээлсэн 24, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар цалингийн тогтоолт, шийдвэрүүд, тооллогын бүртгэлийг анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Малчин сумын Ерөнхий боловсролын сургууль	-	-	-	-	-	-	-	-	-	-
<b>ДҮН</b>											

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

М.БАТСУУРЬ/  
/М.БАТ-АМГАЛАН/  
/Б.ОДГЭРЭЛ/

2022 оны 02 сарын 25-ны өдөр